



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/638

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 08, 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Хөвсгөл салбартай хамтран ажиллах үйл ажиллагаанд 8,000,000 (Найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 8,000,000 (Найман сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд батлагдсан “Худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж, тайлагнаж ажиллахыг Хөвсгөл аймгийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дарга (Д.Гэрэлтуяа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ